



**МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 7а, Утас: 26-21-35,
Факс: (976-11) 32-21-27, E-mail: info@mfa.gov.mn,
<http://www.mfa.gov.mn>

2014.04.02 № 09/3349

танай _____-ны № _____-т

**ИРГЭНИЙ ХАРЬЯЛАЛ, ШИЛЖИЛТ
ХӨДӨЛГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Б.ПҮРЭВДОРЖ ТАНАА**

Белград хотноо 2013 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр гарын үсэг зурсан “Иргэдийг виз авах шаардлагаас харилцан чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Серби Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” нь 2014 оны 7 дугаар сарын 17-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ. Хэлэлцээрийн хуулбарыг хавсаргав.


Энэхүү хэлэлцээрийн дагуу Монгол Улсын болон БНСбербиУ-ын бүх төрлийн паспорт эзэмшигч иргэд зургаан сарын хугацаанд 90 хүртэлх хоног харилцан визгүй зорчих боломжтой юм.

Холбогдох газартаа уламжилна уу.

Хавсралт: 6 хуудас.

**ГЭРЭЭ, ЭРХ ЗҮЙН ГАЗРЫН
ЗАХИРАЛ**

А.ТӨМӨР



0000007021

Монгол Улсын Засгийн газрын
хэрэгжүүлэгч агентлаг
ИРГЭНИЙ ХАРЬАЛАЛ, ШИЛЖИЛТ
ХОДӨЛГӨӨНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР
ТТБ-а. 2052

Бүртгэсэн № 2546
Огноо 2014.07.03

10. цаг 30 минутанд
шилжүүлэв.

Хуудасны тоо 4



**ИРГЭДИЙГ ВИЗ АВАХ ШААРДЛАГААС ХАРИЛЦАН ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
БҮГД НАЙРАМДАХ СЕРБИ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Серби Улсын Засгийн газар (цаашид "Хэлэлцэн тохиолцогч Талууд" гэх),

Хоёр орны улсын хоорондын нөхөрсөг харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэхийг эрмэлзэн;

Хоёр улсын иргэд нөгөө талын нутаг дэвсгэрт харилцан зорчих нөхцлийг хөнгөвчлөх шаардлагыг хүлээн зөвшөөрч;

дараах зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Хэлэлцэн тохиролцогч Талуудын хүчин төгөлдөр дипломат, албан болон энгийн паспорт эзэмшигч иргэд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт нэвтрэн орох, гарах, дамжин өнгөрөх болон түр хугацаагаар оршин суухад виз авах шаардлагаас зургаа хүртэлх сарын хугацаанд ер (90) хүртэл хоног чөлөөлөгдөнө.

2 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч Талуудын иргэд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт нэвтрэн орох, гарах, дамжин өнгөрөхдөө олон улсын иргэний тээвэрт зориулсан бүх хилийн боомтоор нэвтрэх эрхтэй.

3 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохиролцогч Талуудын иргэд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байх хугацаандаа хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг нь даган биелүүлнэ.
2. Хэлэлцэн тохиролцогч Талууд гадаадын иргэдийн зорчих, шилжин хөдлөх болон оршин суух тухай өөрсдийн дотоодын хууль тогтоомжид орсон аливаа өөрчлөлтийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа дипломат шугамаар аль болох шуурхай мэдэгдэнэ.

4 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын тааламжгүй гэж үзсэн иргэнийг өөрийн нутаг дэвсгэрт оруулахаас татгалзах, түр оршин суух эрхийг түдгэлзүүлэх Хэлэлцэн тохиролцогч Талуудын эрхийг хөндөхгүй.

5 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохиролцогч Талууд хүчин төгөлдөр дипломат, албан болон энгийн паспортын загваруудаа энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсанаас хойш 30 (гуч) хоногийн дотор дипломат шугамаар харилцан солилцоно.
2. Хэлэлцэн тохиролцогч Талууд шинэ дипломат, албан болон энгийн паспорт нэвтрүүлэх буюу өөрсдийн ашиглаж буй паспортуудыг шинэчлэх тохиолдолд тухайн өөрчлөлт хүчин төгөлдөр болох өдрөөс доод тал нь гуч (30) хоногийн өмнө дипломат шугамаар харилцан мэдэгдэж, тухайн паспортын загварыг болон хэрэглэх тухай мэдээллийг харилцан солилцоно.

6 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохиролцогч Тал тус бүр нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журам болон эрүүлийг хамгаалах үүднээс энэхүү Хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түр хугацаагаар зогсоох эрхтэй.
2. Ийнхүү Хэлэлцээрийн үйлчлэлийг зогсоох тухай мэдэгдлийг Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа дипломат шугамаар аль болох эрт мэдэгдэнэ. Хэлэлцэн тохиролцогч Талууд Хэлэлцээрийн үйлчлэлийг сэргээсэн тухайгаа дээр дурдсаны дагуу мэдэгдэнэ.

7 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч Талууд дипломат шугамаар харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү Хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулж болно. Нэмэлт өөрчлөлт нь энэхүү Хэлэлцээрийн 8 дугаар зүйлд заасны дагуу хүчин төгөлдөр болно.

8 дугаар зүйл

1. Энэхүү Хэлэлцээрийг хугацаагүй байгуулах бөгөөд Хэлэлцэн тохиролцогч Талууд энэхүү Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгох дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухай харилцан мэдэгдсэн сүүлчийн ноот бичгийг хүлээн авсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү Хэлэлцээрийг Хэлэлцэн тохиролцогч аль ч Тал дипломат шугамаар цуцалж болно. Ийнхүү цуцалсан тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ер (90) хоногийн дараа энэхүү Хэлэлцээр цуцлагдана.

Энэхүү Хэлэлцээрийг Белград хотноо 2013 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр монгол, серби болон англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Хэлэлцээрийг тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



БҮГД НАЙРАМДАХ СЕРБИ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ





**AGREEMENT BETWEEN
THE GOVERNMENT OF MONGOLIA AND
THE GOVERNMENT OF THE REPUBLIC OF SERBIA
ON THE EXEMPTION OF VISA REQUIREMENTS
FOR THEIR RESPECTIVE NATIONALS**

The Government of Mongolia and The Government of the Republic of Serbia (hereinafter referred to as the "Parties"),

Desiring to strengthen the bonds of friendship and cooperation between the two countries,

Recognizing the need to facilitate travels into each other's territory by nationals of both countries,

have agreed as follows:

Article 1

The nationals of either Party, holders of a valid Diplomatic, Official and Ordinary passport, shall be exempt from visa requirements to enter, exit, transit through and stay in the territory of the other Party for a period not exceeding ninety (90) days during a period of six months following the date of first entry.

Article 2

The nationals of either Party may enter, transit through, and leave the territory of the other Party at all border-crossing points open to international passenger traffic.

Article 3

1. The nationals of either Party shall comply with the laws and regulations in force in the territory of the other Party, during their stay.

2. The Parties shall, as soon as possible, inform each other through diplomatic channels of any changes in their respective laws and regulations concerning entry, movement and stay of foreigners.

Article 4

This Agreement does not curtail the right of either Party to deny entry or to cancel the stay of the nationals of the other Party who are considered undesirable.

Article 5

1. The Parties shall exchange, through diplomatic channels, specimens of their valid Diplomatic, Official and Ordinary Passports, no later than thirty (30) days after the date of signature of this Agreement.
2. In case of introduction of new Diplomatic, Official and Ordinary Passports or modification of the existing ones, the Parties shall convey to each other, through diplomatic channels, specimens of these passports, as well as information relating to their application, not later than thirty (30) days prior to their application.

Article 6

1. For reasons of public security, public order or public health, either Party may suspend the application of this Agreement in whole or in part.
2. The suspension shall be notified to the other Party through diplomatic channels at the earliest possible time. The Parties shall act in the same way in case of revocation of this measure.

Article 7

This Agreement may be amended by mutual consent between the Parties, through diplomatic channels. Amendments shall enter into force as provided under Article 8 of this Agreement.

Article 8

1. This Agreement shall be valid for an indefinite period and shall enter into force thirty (30) days from the date of receipt of the second diplomatic note in which the Parties inform each other that the national legal requirements for entry into force of this Agreement have been met.
2. Each of the Parties may, at any time, denounce this Agreement through diplomatic channels. The denunciation shall be effective ninety (90) days after the receipt of the notification.

Done at Belgrade on *8th* November 2013, in two original copies, in the Mongolian, Serbian and English languages, all texts being equally authentic. In case of any divergence of interpretation, the English text shall prevail.

**FOR THE GOVERNMENT
OF MONGOLIA**

A stylized, handwritten signature in black ink, likely belonging to a Mongolian official.

**FOR THE GOVERNMENT
OF THE REPUBLIC OF SERBIA**

A handwritten signature in black ink, likely belonging to a Serbian official, written in a cursive style.